

*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 201.. оны .. сарын ..-ны өдрийн ..
дугаар тушаалын хавсралт*

ШИНЭ ТЕХНОЛОГИОР ҮЙЛДВЭРЛЭСЭН ХҮНСИЙГ БҮРТГЭХ, НИЙТИЙН ХЭРЭГЦЭЭНД ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн Монгол Улсад шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг Монгол Улсын дотоодын хүнсний боловсруулах салбарт шинэ технологиор хүнс үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.

Хоёр. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг тодорхойлох

2.1. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс (цаашид “шинэ хүнс” гэх) гэж Хүнсний тухай хуулийн 3.1.8-д заасны дагуу Монгол Улсад урьд өмнө үйлдвэрлэж, практикт хэрэглэж байгаагүй, шинжлэх ухаан, технологийн дэвшилтэт аргаар үйлдвэрлэсэн, эсхүл шинэ технологийг импортлон үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй нь батлагдсан, хуульд заасны дагуу эрхийн хамгаалалт хийгдсэн хүнсийг ойлгоно.

2.2. Шинэ хүнсний хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийг Хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу үнэлнэ.

2.3. Шинэ хүнсний хууль эрхийн хамгаалалт хийгдсэн нотлох ажиллагааг Оюуны өмчийн эрхийн хууль тогтоомжид заасны дагуу оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гүйцэтгэнэ.

Гурав. Шинэ хүнсийг улсын бүртгэлд бүртгэх

3.1. Шинэ хүнсийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж дараах бичиг баримтыг бүрдүүлж хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хүнсний үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ:

3.1.1. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт (хавсралт 1);

3.1.2. шинэ хүнсний хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийг үнэлсэн тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт;

3.1.3. шинэ хүнсийг хууль эрхийн хамгаалалт хийгдсэнийг нотлох оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт.

3.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинэ хүнсийг тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт ирүүлсний дараа ажлын 5 хоногт багтаан улсын бүртгэлд бүртгэж, бүртгэлийн дугаар олгоно.

3.3. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд тухайн шинэ хүнсний талаар дүгнэлт гаргах мэргэжлийн ажлын хэсгийг томилон ажиллуулж, энэ журмын 3.2-т заасан хугацааг ажлын 14 хоногоор сунгаж болно.

3.4. Шинэ хүнсний бүртгэлийн хүчинтэй хугацаа энэ журмын 6.1.1-6.1.5-д заасан үндэслэлээр хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн шинэ хүнсний бүртгэлийг хүчингүй болгох хүртэл үйлчилнэ.

Дөрөв. Шинэ хүнсний бүртгэлийн дугаар

4.1. Шинэ хүнсний бүртгэлийн дугаар NFiMon (New Foods in Mongolia) болон 12 тооноос бүрдэнэ.

4.2. Бүртгэлийн дугаарын эхний дөрвөн тоо нь Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн гадаад худалдааны барааны ангиллын тухайн бүтээгдэхүүнд хамаарах мөрийн дугаартай ижил байна.

4.3. Бүртгэлийн дугаарын 5-10 дахь тоо нь тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн огноо (он, сар, өдөр)-г илэрхийлнэ.

4.4. Бүртгэлийн дугаарын 11-12 дахь тоо нь тухайн оноосон нэр бүхий шинэ хүнсний бүтээгдэхүүнд олгосон дугаар байна.

Тав. Шинэ хүнсийг мэдээлэх, нийтийн хэрэгцээнд гаргах

5.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шинэ хүнсний бүртгэл, мэдээллийн цахим сан байгуулж, олон нийтэд нээлттэй байршуулна.

5.2. Энэ журмын 5.1-д заасан цахим санд шинэ хүнсний талаарх дараах мэдээллийг хадгална:

- 5.2.1. шинэ хүнсний нэр (Монгол, англи хэл дээр);
- 5.2.2. шинэ хүнсний фото зураг (3 хувь);
- 5.2.3. шинэ хүнсний шим тэжээллэг чанарын үзүүлэлт;
- 5.2.4. шинэ хүнсний аюулгүй байдлын үзүүлэлт;
- 5.2.5. шинэ хүнстэй холбоотой санамж, зөвлөмж.

5.3. Бүртгэл, мэдээллийн цахим санд шинэ хүнсний мэдээллийг байршуулсны дараа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн шинэ хүнсийг нийтийн хэрэгцээнд гаргана.

5.4. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тухайн шинэ хүнсийг олон нийтэд сурталчлах, хэрэглээг дэмжих зорилгоор салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтран ажиллана.

Зургаа. Шинэ хүнсний бүртгэлийг хүчингүй болгох,
мэдээллийн сангаас хасах

6.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас дараах тохиолдолд шинэ хүнсний бүртгэлийг хүчингүй болгоно:

6.1.1. шинэ хүнс үйлдвэрлэгч тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрөө хүсэлт гаргасан;

6.1.2. шинэ хүнсний хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эрх бүхий байгууллагаас санал гаргасан;

6.1.3. шинэ хүнсний үйлдвэрлэл нь оюуны өмчийн эрхийн хууль тогтоомж зөрчсөн талаар оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас санал гаргасан;

6.1.4. шинэ хүнсний үйлдвэрлэл нь хүнсний чанар, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байгаа талаар мэргэжлийн хяналтын байгууллагаас дүгнэлт, санал гаргасан;

6.1.5. хууль тогтоомжид заасан бусад.

6.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 6.1.1-6.1.5-д заасан аль нэг үндэслэлээр тухайн шинэ хүнсний бүртгэлийг ажлын 5 хоногт багтаан хүчингүй болгож бүртгэл, мэдээллийн цахим сангаас хасна.

Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнсний чанар, аюулгүй байдлын мэргэжлийн хяналтын улсын байцаагч болон оюуны өмчийн улсын байцаагч холбогдох хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулна.

7.2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд улсын байцаагч холбогдох материалыг бүрдүүлэн хуулийн байгууллагад шилжүүлнэ.

ШИНЭ ТЕХНОЛОГИОР ҮЙЛДВЭРЛЭСЭН ХҮНСИЙГ БҮРТГҮҮЛЭХ
ХҮСЭЛТ

Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр	
Хаяг (байршил, утас, цахим хаяг)	
Мэргэжлийн хяналтын байгууллагад бүртгүүлсэн дугаар	
Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний оноосон нэр	
Хүнсний бүтээгдэхүүний хэмжээ, савлагаа, жин	
Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний	

..... (нэр) миний бие Монгол Улсын шинэ технологиор
үйлдвэрлэсэн хүнсний улсын бүртгэлд бүртгүүлэхээр бүрдүүлж өгсөн бичиг баримт
үнэн болно.

..... гарын үсэг, тамга ... он ... сар ... өдөр